

БАТЛАВ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА

Ц.ТУЛГА

2022 оны дугаар сарын –ны өдөр

**“ТӨРИЙН АЛБАН СУРГАЛТ, АЖИЛЛАХ ОРЧИН, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”-ИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хамтрах байгууллага	Хамрагдах албан хаагчдын тоо	Батлагдсан төсөв
НЭГ. ХҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, СУРГАХ ЧИГЛЭЛЭЭР:					
1.1	“Нийслэлийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-ийн дагуу явагдах сургалт: - Хүн төвтэй төрийн үйлчилгээ - Ажлын байр ба баг хамт олны харилцаа - Судалгааны арга зүй - Сургалтын хэрэгцээнд үнэлгээ хийх - Менежментийн манлайллын түвшин - Төрийн албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалт - бусад	жилдээ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	100 албан хаагч	-
1.2	Газрын албан хаагчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхыг нь сайжруулах чиглэлээр зохион байгуулах сургалт: - Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйл /албан тушаалын ажлын байрны сургалт/; - Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор баталсан дүрэм журам; - Ёс зүйн дүрэм, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт; - Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, инженерийн дэд бүтцийн чиглэлээр байгууллагад мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам норм ба дүрэм, стандарт; - Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй; - бусад	II, III улирал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Архивын газар, Дотоод хяналт, хуулийн хэлтэс, бусад	100 албан хаагч	-
1.3	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалт	Тухай бүр	НХААГ		800'000

			СЯ, БХБЯ-ны дэргэд	5-10 албан хаагч	
1.4	Удирдлагын Академийн 1.5-2 жилийн мэргэшүүлэх болон богино хугацааны зайн сургалт	Жилдээ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	8-10 албан хаагч	-
1.5	Салбарын чиглэлээр доктор, магистрантурын сургалтад албан хаагчдыг суралцах боломжоор хангах	Тухай бүр	МАЭ, Барилгын хөгжлийн төв,	5-10 албан хаагч	-
1.6	Албан хаагчдыг мэргэшлийн зэрэг горилох болон сунгах сургалтад суралцуулах	Тухай бүр	МАЭ, Барилгын хөгжлийн төв, Хууль зүйн үндэсний төв	10-15 албан хаагч	-
1.7	Албан хаагчдад хөрвөх чадвар эзэмшүүлэх	Тухай бүр	Захиргаа санхүүгийн хэлтэс	20-30 албан хаагч	-
Дүн					800'000

ХОЁР. АЖИЛЛАЖ, АМЬДРАХ НӨХЦӨЛ БОЛОЛЦОО, НИЙГМИЙН АСУУДЛЫН ТАЛААР:

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Хугацаа	Зохион байгуулах хэлтэс	Батлагдсан хөрөнгө /сая төгрөг/
2.1	Ажлын байр, ажиллах нөхцөлийг сайжруулах	Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах тав тухтай орчныг бий болгохын тулд өрөө тасалгааны агааржуулалт, чийгшүүлэлт, гэрэлтүүлэг, цэвэрлэгээний чанарыг дээшлүүлэх, цэцэрлэгжүүлэх ажлыг зохион байгуулах	тогтмол	ЗСХ, Байнгын үйл ажиллагаатай ажлын хэсэг	-
2.2	Ажилтнуудын орон сууц, газар өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх	Орон сууц болон амины орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх	жилдээ	Захиргааны зөвлөл	-

2.3	Шагнал, урамшил	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэн олгох урамшил, тэмдэглэлт баяраар газрын албан хаагчдыг шагнаж урамшуулах: - Төрийн дээд одон медаль, салбарын болон нутгийн захиргааны байгууллагын шагнал;	жилдээ	20-30 албан хаагч	-
		- Төрийн албан хаагчид ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн олгох мөнгөн урамшуулал.	Улирал бүр	100 албан хаагч	Цалингийн зардлаас гүйцэтгэлээр
2.4	Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах	Албан хаагчдын чөлөөт цагаар төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулж, тэднийг идэвхтэй оролцуулах. /Спорт хамтлагийн жилийн ажлын төлөвлөгөө, баталсан удирдамжийн дагуу	жилдээ	100 албан хаагч	-
2.5	Албан хаагчдад нийгэм ахуйн хөнгөлөлт үзүүлэх, тэтгэвэрт гарсан албан хаагчдад тэтгэмж олгох	Газрын Хөдөлмөрийн дотоод журмын 10 дугаар зүйл: 10.2.1.албан хаагчийн гэр бүлд шинэ хүүхэд мэндэлсэн, нэг хүртэл насны хүүхэд үрчилж авсан бол 150 (нэг зуун тавин мянга) төгрөг; 10.2.2.албан хаагч өөрөө, түүний эхнэр (нөхөр), төрсөн хүүхэд, эцэг эх 1 сараас дээш хугацаагаар өвчилсөн, удаан хугацаанд асрамжлахад нь зориулж 500.0 (таван зуун мянга) төгрөг; 10.2.3.албан хаагч эрүүл мэндийн зайлшгүй шалтгаанаар хагалгаанд орсон тохиолдолд эмчилгээнд нь зориулж 1.0 (нэг сая) төгрөг; 10.2.4.албан хаагчийн эхнэр (нөхөр), хүүхэд нас барвал 500.0 (таван зуун мянга) төгрөг, төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү, хадам эцэг, эх, нас барвал 200.0 (хоёр зуун мянга) төгрөг; 10.2.7.албан хаагч гэр бүл болж хурим хийвэл 500.0 (таван зуун мянга) төгрөг; 10.2.8.албан хаагч төрийн дээд одон медалиар шагнагдахад 300.0 (гурван зуун мянга) төгрөгийн бэлэг дурсгалын зүйл олгоно. 10.3.1.албан хаагчдын 16-аас доош насны хүүхдэд Эх үрсийн баяраар бэлэг авахад нь зориулж хүүхэд тус бүрд 40.0 (дөчин мянга) төгрөг, шинэ жилийн баяраар хүүхэд, гэр бүлд нь бэлэг авахад зориулж 70.0 (далан мянга) төгрөг; 10.3.2.албан хаагчдыг жилд нэг удаа эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд хамруулна. Бусад.	жилдээ	5-10 албан хаагч	1,500'000
				5-10 албан хаагч	10'000'000
				5-10 албан хаагч	2,500'000
				5-10 албан хаагч	3,000'000
				180 хүүхэд	7,200'000
				100 албан хаагч	7,000'000
Дүн					31'200'000
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ					32'000'000